

**11-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН
ДААЛГАВАР**

Хугацаа: 60 минут

Нийт 40 оноо

Ангибүлэг.....

Сурагчийн нэр:.....

ХУВИЛБАР-А

Д.Батбаяр

Харанхуй

Өнөө хэр нь нууцыг нь тайлж чадаагүй байгаа аугаа их юм бол харанхуй.

Харанхуй бол тайлагдашгүй. Тайлагдашгүй бүхэн харанхуй. Харанхуйг хүн тайлж чадахгүй байгаагийн учир бол харанхуйгаас айдагт оршино. Зугтдагт оршино. Үзэн яддагт оршино. Амьд бүхэн зөвхөн нарны гэрэл, тэнгэрийн хураар төрж төлжиж, ургаж цэцэглэж байдаг хэмээх үзэл номлолд олон зуун жил хүлэгдсэн хүний оюун ухаан амьдралын үндэс харанхуйд оршиж байдгийг мартдаг.

Мартсанаа санавал бид харанхуйтай учирна. Харанхуй бол амьдралын хэвлий. Амьд бүхэн харанхуйд бүтэж бүрдэнэ. Бүгд харанхуйгаас эхтэй.

Гэрэл гэгээнд гарсан ч харанхуйн хэвлийгээс хүйгээ тасалж чадахгүй. Харанхуйгүйгээр хүн амьтан, мод чулуу оршиж үл чадна. Харанхуй бол бие сэтгэлийг амирлуулагч. Амар амгалангийн өлгий, оюун ухаан орших орон бол харанхуй. Харанхуйд оюун ухаан хамгийн чөлөөтэй болдог. Харанхуйд хүн гэрэлтэйгээс илүү сэтгэдэг.

Хүн гэрлийг нэгэн цэгт хурааж чадна. Харанхуйг эс чадна. Гэрлийг задалж дотроос нь дуртай туяагаа авч чадна. Харанхуйг эс чадна. Гэрэл бол хүний багаж. Өдөр бүхэн зайдалдаг унаа. Харанхуй бол багаж бус. Унаа бус. Тайлж таньшгүй аюумшигт эмнэг догшин хүлэг.

Харанхуйг таньж мэдэхгүй явах нь ертөнцөд утга учиргүй амьд явахтай дүйцнэ. Харанхуйг таних түлхүүр бол хүн өөрөө ч байж мэднэ. Хүн харанхуй бол чанд орших харанхуй ч байж магадгүй. Хязгаар хярхаггүй үзэгдэл юмс руу бэлчээсэн мэдрэмж, сэтгэмжээ хүн хүн өөр уруугаа эргүүлбэл харанхуйн зах харагдаж мэднэ. Гэрлийн дунд алмайрч хэрхэхээ мэдэхгүй будилж явсан оюун ухаан тань торноос ниссэн харцага адил харанхуйн гүн рүү нисэн одож ч мэднэ.

Харанхуйг таних гэгч дотогшоо харахын ч нэр байж магадгүй. Харанхуй мөнх гэгчийн сүүдэр ч байж магадгүй.

Ажиллах даалгавар:

1. “Харанхуйг хүн тайлж чадахгүй байгаа нь харанхуйгаас айдагт оршино.” Өгүүлбэрийн бүтэц хэв шинжийг тодорхойлж, холбогдсон аргыг тайлбарлаарай. \4оноо\

Холбогдсон арга нь:

.....
.....

Өгүүлбэрийн хэв шинж нь:

.....
.....

2. “Ухаанд нь ухна ишиг үхсэн юм шиг” хэлцийн утгыг тайлбарлан бичээрэй. /4 оноо/

.....
.....
.....

3. “Мартсанаа санавал бид харанхуйтай учирна.” Нийлмэл өгүүлбэрийн онцолсон бүтээврийн утга үүргийг тодорхойлж, ойролцоо утгатай бүтээврээр солин найруулж бичээрэй. /4оноо/

Тодорхойлсон нь:

.....
.....

Солин найруулсан нь:

.....
.....

4. “Эргүүлбэл” хэмээх үгийн зөв бичгийн дүрмийг тайлбарлан бичнэ үү? \2оноо\

Дүрэм нь:

5. “Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “Л” дагаврыг залган бичихдээ эгшийг өмнө нь бичнэ” гэсэн дүрэмд тохирох жишээ үг эхээс олж бичнэ үү? \2оноо\

Жишээ үгс:

6. Антон Павлович Чехов “Хамелеон” өгүүллэгээр дамжуулан зохиолчийн хэлэх гэсэн санааг хэлцээр илэрхийлж өөрт төрсөн мэдрэмж сэтгэгдэлдээ тулгуурлан 40-50 үгэнд багтаан тайлбарлана уу?\ 5 оноо\

.....
.....
.....
.....

7. “Цаг хугацаа...” сэдвээр эргэцүүлсэн эсээ бичихдээ сэдэв, агуулгын уялдаа холбоог гаргаж, уран дүрслэл, хэл найруулгыг оновчтой хэрэглэн, алдаагүй цэвэр сайхан бичнэ үү. Үгийн тоо 150-180 /10 оноо/

.....

Ээж нь судар тэвэрч
Сүм гороолно
Сэтгэл нь амирлана. \А. Далхжав\

Далд утга:

.....
.....
.....

10. Үндэсний бичгээс кирилл рүү хөрвүүлэн бичээрэй. /5 оноо/

ᠪᠠᠭᠠᠨ ᠰᠡᠩᠭᠡᠨ ᠮᠡᠮ ᠰᠢᠨ
ᠰᠢᠨᠭᠡᠨ ᠰᠡᠩᠭᠡᠨ ᠰᠡᠩᠭᠡᠨ ᠰᠡᠩᠭᠡᠨ ᠰᠡᠩᠭᠡᠨ
ᠰᠡᠩᠭᠡᠨ ᠰᠡᠩᠭᠡᠨ ᠰᠡᠩᠭᠡᠨ ᠰᠡᠩᠭᠡᠨ ᠰᠡᠩᠭᠡᠨ

**11-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ
ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР**

Хугацаа: 60 минут

Нийт 40 оноо

Ангибүлэг.....

Сурагчийн нэр:.....

ХУВИЛБАР-Б

Д.Урианхай

Ой

Ойн захад очоод дотогш харахад гүнд нь буй юмс эс харагдана.

Ой дотроо байгаа ч юм уу гүндээ байгаа юмыг хүний нүднээс баттай халхлан хаана.

Сүслэн бодвол миний амнаас унаж буй “халхална”, хаана” гэдэг үгийн оронд “өвөртлөн үлдэнэ”, “хаацайлна”, магадгүй “харамлана”, бүүр магадгүй, “хамгаална”, аварна” гэх үгс ч илүү нүдээ олох байж мэднэ.

Ямар ч бага, ямар ч сийрэг ой байлаа гэсэн захад нь байхад голд нь байгаа юм, халим л эс халхалж, луу л эс лухайвал, юу ч байсан эс харагдана. Эл чанар ой хөвчийн гол чанар гэж би бодно.

Ойн зах руу орж, гүн руу нь лавхан дотогшиллоо...

Ой, дотроо тийм ч шивэр, ягц, балар биш аж! Модод хичнээн шигүү ургалаа ч бие биеэсээ, багаар бодоход, тохой тохой зайтай, заримдаа ч алд алдын зайтай хол ургажээ.

Уул нүүнэ... Шувууд нисэлдэнэ... Ой шуугина...

Удаан хэвтлээ...

Навчис хөдөлнө... Навчис сэрчигнэнэ... Навчис шуургална... Навчис! Навчис! Навчис!
Навчис! Навчис!.. Бодлоо....

"Ой, гүндэхээ хүний нүднээс далдалж чаддагийн увдис нь навчистаа байдаг юм байна! Ой модны навч мөчир ургахдаа бие биеэ нөмөрлөх, бие биеэ тэврэх гэж тэмүүлэх мэт бие бие рүүгээ зүтгэж, бие биеэ нөхөж, бие биедээ дутаж, бие биеэ үгүйлэх гэх мэт бие биедээ татагдаж, бие биеэсээ зугтах бус, бие бие рүүгээ зүглэж, бие биеэсээ явах бус ирж, тарах бус цуглаж, бие биетэйгээ харгалдах бус ханьсаж, хаа онгорхой сиймхий харагдана вэ, тэр заагийг нэг нь дүүргэж, завсар завсараа шахсанаар ой мод тийн эвийн далайгаар хөвч болон хөглижээ! Эв гэдэг ихийгээ ч, багыгаа ч, илийгээ ч, далдыгаа ч бусдаас батлах... ариглан хадгалах... авран сахихын рид хутгийг өршөөгч ажээ!"

Удаан хэвтлээ... Үүл нүүнэ... Шувууд ниснэ... Ой шуугина... Ойн гүн рүү юу ч эс харагдана...

1. Ойн захад очоод дотогш харахад гүнд нь буй юмс эс харагдана. ” Өгүүлбэрийн бүтэц хэв шинжийг тодорхойлж, холбогдсон аргыг тайлбарлаарай. \4оноо\

Холбогдсон арга нь:

.....
.....

Өгүүлбэрийн хэв шинж нь:

.....
.....
2. “Шуудайд хийсэн үхрийн эвэр шиг” хэлцийн утгыг тайлбарлан бичээрэй. \4оноо\

.....
.....
3. “Мөчир нь завсар завсраа шахсанаар ой мод хөвч болжээ” Нийлмэл өгүүлбэрийн онцолсон бүтээврийн утга үүргийг тодорхойлж, ойролцоо утгатай бүтээврээр солин найруулж бичээрэй. /4оноо/

Тодорхойлсон нь:

.....
Солин найруулсан нь:

.....
4. “Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “Л” дагаврыг залгахдаа балархай эгшгийг ард нь бичнэ” гэсэн дүрэмд тохирох жишээ эхээс олж бичнэ үү? \2 оноо\

Жишээ

Үг.....

5. “ Бодоход “ хэмээх үгийн зөв бичгийн дүрмийг тайлбарлана бичнэ үү? \2оноо\

Дүрэм нь:

6. Антон Павлович Чехов “Хамелеон” өгүүллэгээр дамжуулан зохиолчийн хэлэх гэсэн санааг хэлцээр илэрхийлж өөрт төрсөн мэдрэмж сэтгэгдэлдээ тулгуурлан 40-50 үгэнд багтаан тайлбарлана уу?\ 5 оноо\

.....
.....
.....
.....
7. “Цаг хугацаа...” сэдвээр эргэцүүлсэн эсээ бичихдээ сэдэв, агуулгын уялдаа холбоог гаргаж, уран дүрслэл, хэл найруулгыг оновчтой хэрэглэн, алдаагүй цэвэр сайхан бичнэ үү. Үгийн тоо 150-180 /10 оноо/

Далд утга:

.....

.....

10. Үндэсний бичгээс кирилл рүү хөрвүүлэн бичээрэй. /5 оноо/

ᠰᠡᠭᠡᠨ ᠰᠡᠭᠡᠨ ᠰᠡᠭᠡᠨ ᠰᠡᠭᠡᠨ ᠰᠡᠭᠡᠨ
ᠰᠡᠭᠡᠨ ᠰᠡᠭᠡᠨ ᠰᠡᠭᠡᠨ ᠰᠡᠭᠡᠨ ᠰᠡᠭᠡᠨ